



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Дүүргийн мэтгэлцээний аварга шалгаруулах
“Оролцоод хөгжье” тэмцээн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд иргэд, залуучуудын оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор “Оролцоод хөгжье” мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах 1,935,000 (нэг сая есөн зуун гучин таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны... дугаар сарын...ны өдрийн
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ
АВАРГА ШАЛГАРУУЛАХ “ОРОЛЦООД ХӨГЖЬЕ” ТЭМЦЭЭНИЙ
УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

“Бүтээмж-хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил”, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Оюунлаг Багахангайчууд” төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойг угтан залуучуудын оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх, орон нутагт тулгарч буй асуудалд ул суурьтай хандах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, өөрийн бодлоо зөв цэгцтэй илэрхийлэх замаар багаар ажиллах, оюуны дархлааг нэмэгдүүлэхэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Багахангай дүүргийн Аж ахуйн нэгж, албан байгууллагын ажилтан албан хаагчид, иргэд, оюутан, залуучууд

ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, “Сүлд” карл попперийн мэтгэлцээний клуб

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Монголын мэтгэлцээний нэгдсэн танхим

ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ҮЕ ШАТ:

1. Мэтгэлцээний сургалт (Аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчид, иргэд)
2. Насанд хүрэгчдийн аварга шалгаруулах мэтгэлцээн

ХААНА, ХЭЗЭЭ:

Мэтгэлцээний сургалт 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09.00-17.00 цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд

Насанд хүрэгчдийн аварга шалгаруулах мэтгэлцээн 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 09.00 цагт дүүргийн Соёлын ордонд тус тус зохион байгуулагдана.

МЭТГЭЛЦЭХ ШИЙДЛҮҮД:

1. Иргэний хяналт төрийн хяналтаас илүү байх нь зүйтэй
2. Жендэрийн эрх тэгш байдал нийгэмд ашигтай
3. Хүний эрх гэж хэт туйлшрах нь буруу
4. Мод тарих нь цөлжилтөөс сэргийлэх цорын гац арга зам мөн

4. Мод тарих нь цөлжилтөөс сэргийлэх цорын гац арга зам мөн
5. Том голын жижиг загас байснаас - Жижиг голын том загас байсан нь дээр
6. Хайран дээр суурилсан гэр бүлээс – Тооцоолол дээр суурилсан гэр бүл дээр
7. Цувж явсан барнаас – Цуглаж суусан шаазгай дээр
8. Ухаалаг гар утас гэр бүлийн халуун дулаан уур амьсгалд сөрөг нөлөөтэй
9. Дуртай зүйлээ хийснээс хэрэгтэй зүйлээ хийсэн нь илүү үр ашигтай
10. Өрсөлдөөн нь хамтын ажиллагаанаас илүү хөгжлийн түлхэц болдог

ТЭМЦЭЭНИЙ ЖУРАМ:

1. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага бүр баг бүрдүүлж оролцоно (Жич: Хүн хүрэлцэхгүй байгууллагууд нэгдэж оролцож болно)
2. Баг тус бүр 2 гишүүнтэй байна.
3. Дүүрэгт ажиллаж амьдарч байгаа иргэд болон оюутан залууст нээлттэй.
4. Парламентын мэтгэлцээний үндсэн хугацаанаас 1 минутын хасалттай явагдана.
5. Насанд хүрэгчдийн мэтгэлцээнд оролцох багийн мэдүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 17.00 цагийн дотор ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэст ирүүлнэ
6. Хагас шигшээд шалгарсан багууд хасагдах зарчмаар мэтгэлцэнэ.

Шагнал урамшуулал:

- I байр Өргөмжлөл, (300,000) мөнгөн шагнал
- II байр Өргөмжлөл, (200,000) мөнгөн шагнал
- III байр Өргөмжлөл, (100,000) мөнгөн шагнал

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 15 дугаар сарын 28 ны өдрийн
1785 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ
АВАРГА ШАЛГАРУУЛАХ “ОРОЛЦООД ХӨГЖЬЕ” ТЭМЦЭЭН ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ус	ш	60	1500	90,000
Мэтгэлцээний сургалт					
2	Сургагч багшийн хөлс	хүн	2	300,000	600,000
Насанд хүрэгчдийн мэтгэлцээний тэмцээн					
3	Шүүгч	хүн	2	300,000	600,000
	1-р байр	ш	1	300,000	300,000
	2-р байр	ш	1	200,000	200,000
	3-р байр	ш	1	100,000	100,000
	Жааз		3	15,000	45,000
Нийт					1,935,000